



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар A/29

Арвайхээр

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч иргэн, байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын 13 дугаар баг, Д.Пүрэвдорж-б дугаар гудамж, 605 тоотод байрлах аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын (9046143) эзэмшлийн төрийн байгууллагын зориулалттай 3282м² газрыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газарт (3555739) зориулалтын дагуу 11 жил, 13 дугаар баг, Дөл-7 гудамж, 709 тоотод байрлах Норинпэлийн Батаахүүгийн (ЙИ78031911) эзэмшлийн амины орон сууцны зориулалттай 450м² газрыг Хоролсурэнгийн Лхагвадоржид (ЙЮ90072630) зориулалтын дагуу 12 жилийн хугацаатайгаар тус тус газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны A/72 дугаар захирамж, 2019 оны A/535 дугаар захирамжийн хавсралтын Н.Батаахүүтэй холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

А.ИШДОРЖ

6222 11 0061

D:My Doc. Zahiramj. Zasag darga